



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Булган өрхийн эрүүл мэндийн төвийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/006/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatarkhu@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: С.Оюунжаргал Утас: 70432545 Цахим хаяг: Oyunjargals @audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	7
3.1. Төлбөрийн акт.....	7
3.2. Зөвлөмж.....	7
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	10
5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ	11

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
НА	Нийцлийн аудит
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ХОА	Ховд аймаг

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.03.13 № 840

танай _____-ны № _____-т

БУЛГАН СУМЫН БУЛГАН ӨРХИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
А.ТҮМЭНБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Булган сумын Булган өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр "Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл" хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 3.12-т "Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэр гаргана" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7.байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах. нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.3.нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, мэдээг гарган энэ хуулийн 25.1-д заасан хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэх гэсэн заалтуудтай тус тус

8426050579

нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант онд 3,939.8 мянган төгрөгийн бараа, үйлчилгээний үнийг давхардуулж олгосон, авлагаар бүртгээгүй, төсвийн хөрөнгөөр 500.0 мянган төгрөгийн үрэлгэн зардлыг санхүүжүүлсэн;
- Бараа материалын тайланг шаардах хуудсаар зарлагдаагүй, зарим бараа материалыг бөөн дүнгээр орлого авч, бараа материал зарцуулагдаагүй байхад шууд зарлагадсан, анхан шатны баримтын бүрдэлгүй 16,266.08 мянган төгрөгийн ажил гүйлгээг санхүүжүүлсэн;
- Жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодолгүйгээр 35,320.40 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан шатахуунд тавих дотоод хяналт хэрэгжүүлээгүй;
- Албан хаагчдаас нийгмийн даатгалын шимтгэл дутуу суутган олгож, цалин хөлсийг зөрүүтэй тооцсон байгууллагын төсвөөс 2,084,9 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн;
- Зарим эм эмнэлгийн хэрэгслийг түүвэрлэн хянахад 14,358.2 мянган төгрөгийн эм тариаг өндөр өртөгтэй авч төсвийг үрэлгэн зарцуулсан;
- Өрхийн эрүүл мэндийн төвийн даргад эрх бүхий дээд шатны удирдлагын тушаал шийдвэргүйгээр улирлын үр дүнгийн нэмэгдэл, илүү цаг олгосон;
- Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал, байгууллагын төсвөөс худалдан авсан суурин компьютер, дэлгэц, проктер, принтерийг үндсэн хөрөнгөд бүртгэж аваагүй;

Асуудлыг онцолсон хэсэг

Өрхийн эрүүл мэндийн төв нь орон нутгийн өмч ашиглан зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн хэлбэрээр ажиллаж байгаа боловч эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөг эрх бүхий этгээдээр батлуулаагүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 636,229.95 мянга, аймгийн ЗДТГ-аас тогтмол, зардлын санхүүжилт 16,444.84 мянга, Эрүүл мэндийн газраас 8,760.61 мянга нийт, 661,501.40 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 679,921.49 мянган төгрөгийг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн байна

Бусад асуудлын хэсэг

Эрт илрүүлэгт өссөн дүнгээр 3052 хүн, өдрийн эмчилгээнд 366 хүн, гэрээр тусламж үйлчилгээг 212 хүн, сэргээн засах 168 хүн тус тус хамрагдаж эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ авсан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Үлдэгдэл	
		01-р сарын 01	12-р сарын 31
А	Б	1	2
1.1	Эргэлтийн хөрөнгө	32,336,627	24,823,151
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,113,762	3,426,917
1.1.2	Дансны авлага	17,733,250	8,257,661
1.1.4	Бусад авлага	581,800	581,800
1.1.6	Бараа материал	9,907,814	12,556,774
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	32,336,627	24,823,151
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,090,959,582	1,047,784,432
1.2.2	Биет бус хөрөнгө	6,000,000	6,000,000
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,096,959,582	1,053,784,432
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,129,296,209	1,078,607,583
2.1.1.13	Бусад богино хугацаат өр төлбөр	8,965,000	0.00
2.1.1.16	Богино хугацаат өр төлбөрийн дүн	8,965,000	0.00
2.1.2.20	Өр төлбөрийн нийт дүн	8,965,000	0.00
2.2.1	Өмч : а) төрийн	1,009,371,300	1,009,371,300
2.2.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	24,571,200	24,571,200
2.2.7	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	16,600,000	16,600,000
2.2.8	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	69,788,709	28,065,083
2.2.20	Эзэмшигчдийн өмчийн дүн	1,120,331,209	1,078,607,583
2.3.20	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,129,296,209	1,078,607,583

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Дэс дугаар	Үзүүлэлт	(төгрөгөөр)	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	451,114,573.00	535,533,688.00
3	Нийт ашиг (алдагдал)	451,114,573.00	535,533,688.00
8	Бусад орлого	42,705,309.00	166,820,758.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	463,379,583.00	595,699,323.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	(32,784,706.00)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	30,440,299.00	73,870,417.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	30,440,299.00	73,870,417.00
24	Орлогын нийт дүн	30,440,299.00	73,870,417.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Д/д	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	1,009,371,300	24,571,200	16,600,000	69,788,709	1,120,331,209
3	Залруулсан үлдэгдэл	1,009,371,300	24,571,200	16,600,000	69,788,709	1,120,331,209
9	2024 оны 12-р сарын 31-ний өдөр	1,009,371,300	24,571,200	16,600,000	69,788,709	1,120,331,209
11	Залруулсан үлдэгдэл	1,009,371,300	24,571,200	16,600,000	69,788,709	1,120,331,209
12	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/				(41,723,626)	(41,723,626)
17	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,009,371,300	24,571,200.00	16,600,000	28,065,083	1,078,607,583

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1.1	Мөнгөн орлогын дүн	659,418,170.10	679,234,647.55
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	644,891,365.00	654,029,199.05
	Бусад мөнгөн орлого	14,526,805.10	25,205,448.50
1.2	Мөнгөн зарлагын дүн	658,210,117	671,004,493.00
	Ажиллагчдад төлсөн	368,365,673.14	435,195,416.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	94,250,586.00	54,504,317.14
	Бараа материал худалдан авахад төлсөн	114,837,107.00	105,138,166.20
	Ашиглалтын зардалд төлсөн	27,892,426.43	16,495,694.00
	Түлш шатахуун тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	35,901,450.00	35,320,400.00
	Бусад	16,962,874.43	24,350,499.66
1.30	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,208,053.10	8,230,154.55
2.2	Мөнгөн зарлагын дүн /- /	0.00	8,917,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	8,917,000.00
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,208,053.10	(686,845.44)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,905,709.15	4,113,762.25
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,113,762.25	3,426,916.81

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 93,508.42 мянган төгрөгийн 9 зөрчил¹ илэрснээс, 4,439.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх 1 төлбөрийн акт, зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 89,068.62 мянган төгрөгийн 8 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй нийт 93,508.42 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

3.1. Төлбөрийн акт

3.1.1 Илрүүлэлт: Торгон нутгийн хишиг ХХК-руу 576,6 мянган төгрөг, Мөнх эвээлт зам ХХК-руу 863.20 мянган төгрөгийн бараа материалын тооцоог давхардуулж олгосон, авлагаар бүртгээгүй, байгууллагын даргын А/15 дугаар тушаалаар Эрүүл мэндийн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ой арга хэмжээнд 3,780.0 мянган төгрөгийг зарцуулж тайлагнасан ч давхардуулж 2,500.0 мянган төгрөг олгосон байгууллагын төсвөөс архи согтууруулах ундааны зүйл худалдан авсантай холбоотой 4,439.8 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн “6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах."Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.7.байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах.” гэсэн заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3.2. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Цалингийн нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга өөрөө өөртэй үр дүнгийн мөнгөн урамшуулал, илүү цаг тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 3.12-т “Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэр гаргана” гэсэн заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж Өрхийн эрүүл мэндийн төвийн даргад улирлын үр дүнгийн нэмэгдэл болон илүү цагийг дээд шатны байгууллагын удирдлагаар шийдвэр гаргуулан олгох.

3.2.2 Цалингийн нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Албан хаагчдаас нийгмийн даатгалын шимтгэл дутуу суутган олгож, цалин хөлсийг зөрүүтэй тооцсон байгууллагын төсвөөс нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нь 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 16.5.5-д батлагдсан төсвийг зориулалтын дагуу

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зарцуулах; нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.3-д ”нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, мэдээг гарган” гэсэн заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Албан хаагчдаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооллыг хянаж зөрүүг тооцож суутгах

3.2.3 Бараа материалын зардалтай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Бараа материалын тайланг шаардах хуудсаар зарлагдаагүй, зарим бараа материалыг бөөн дүнгээр орлого авч, бараа материал зарцуулагдаагүй байхад шууд зарлагдсан, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн 16,266.08 мянган төгрөгийн зөрчил нь төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн “6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, гэсэн заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын тайланг үнэн зөв гаргаж, анхан шатны баримтгүй ажил гүйлгээг санхүүжүүлэхгүй байх

3.2.4 Шатахууны зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодолгүйгээр шатахуун зарцуулж дотоод хяналт хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн “6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-г "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн замын хуудас хөтлөн, шатахуун зарцуулалтын тооцоог тухай бүр бодож ажиллах

3.2.5 Бараа материалын зардалтай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Зарим эм эмнэлгийн хэрэгслийг түүвэрлэн хянахад Булган сумын эмийн эргэлтийн сан, эмийн сангаас өндөр үнээр эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авч төсвийг үрэлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн “6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, 4.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дээд шатны байгууллагад эм, эмнэлгийн хэрэгслийн тоо хэмжээг өгч ерөнхий гэрээгээр төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан авалт хийж төсвийн хөрөнгийн үр ашигтай зарцуулах

3.2.6 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал, байгууллагын төсвөөс худалдан авсан суурин компьютер, дэлгэц, проктер, принтерийг үндсэн хөрөнгө, бараа материал дансанд бүртгэж аваагүй нь, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-г "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д ”Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх,

санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” 14 дүгээр зүйлийн 14.4.5-д "бүх орлого"; нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: 2026 оны эхний хагас жилд багтаан байгууллагын төсвөөс авсан 11,637.94 мянган төгрөгийн өртөгтэй хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг данс бүртгэлд тусгах

3.2.7 Ойн арга хэмжээний зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын даргын А/14 дүгээр тушаалаар Булган сумын соёлын төвд 500.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн газарт 1000,0 мянган төгрөгийн ойн хандив, баруун бүсийн сургалт арга хэмжээ болон ойн арга хэмжээнд 7,009.1 мянган төгрөг зарцуулж төсвийг үрэлгэн зарцуулсан нь, Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн “6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж хууль тогтоомжид нийцээгүй зардал гаргахгүй байх

3.2.8 Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал.

Илрүүлэлт: shilendams.gov.mn цахим сайтад Булган-өрх нэрээр цэс нээлгэсэн ч мэдээлэл оруулаагүй байгаа зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн гуравдугаар зүйлийн 3.1.5.төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч, 6 дугаар зүйлийн 6.9-д 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй гэсэн хуулийн заалтууд, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж цахим системд мэдээлэл оруулах

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-г заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

(мянган төгрөгөөр)

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хуульд		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Булган ӨЭМТ	Байгууллагын дарга өөртөө үр дүнгийн урамшуулал, илүү цаг тооцож олгосон	1						1				
	Тайлант онд бараа, үйлчилгээний үнийг давхардуулж олгосон, авлагаар бүртгээгүй төсвийн хөрөнгөөр мянган төгрөгөөр архи согтууруулах ундаа бэлтгэсэн	1	4,439.8	1	4,439.80							
	Ойн арга хэмжээнд хөрөнгө гаргаж төсвийг үр ашиггүй зарцуулсан	1	9,401.00						1	9,401.00		
	Бараа материалын тайланг шаардах хуудсаар зарлагдаагүй, зарим бараа материалыг бөөн дүнгээр орлого авч, бараа материал зарцуулагдаагүй байхад шууд зарлагдсан, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн	1	16,266.08						1	16,266.08		
	Жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодолгүйгээр шатахуун зарцуулсан шатахуунд тавих дотоод хяналт хэрэгжүүлээгүй	1	35,320.40						1	35,320.40		
	Албан хаагчдаас нийгмийн даатгалын шимтгэл дутуу суутган олгож, Цалин хөлсийг зөрүүтэй тооцсон байгууллагын төсвөөс нийгмийн даатгалын шимтгэл төлсөн	1	2,084.99						1	2,084.99		
	shilendams.gov.mn цахим сайтад Булган-өрх нэрээр цэс нээлгэсэн ч мэдээлэл оруулаагүй	1							1			
	Эм, эмнэлгийн хэрэгслийг өндөр өртөгтэй авч төсвийг үрэлгэн зарцуулсан.	1	14,358.20						1	14,358.20		

	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал, байгууллагын төсвөөс худалдан авсан	1	11,637.94					1	11,637.94		
	ДҮН	9	93,508.42	1	4,439.80			8	89,068.62		

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНӨҮГ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		